



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар A/100

Батноров сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын /Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам/-ын 3.6.16 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 16 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батноров сумын нутаг Баян 3 дугаар багийн Дунд Баяны энгэр, Алтан-Овооны баруун талд нутагшуулсан 50 тарвагыг хамгаалж буй идэвхтэн Байгаль хамгаалагч Баатарсүрэн овогтой Ганцоожийн тарвага хамгаалж буй мэдээ тайланг харгалзан үзэж 3000000 (Гурван сая төгрөг)-ийг урамшуулал олгосугай.
2. Урамшууллын 3000000 (Гурван сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү албаны нягтлан бодогч (Б.Энхжаргал)-д үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Өсөхбаяр)-д даалгасугай.



Б.ЖАВХЛАНБАЯР